



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

Г Дэд хорооны бүрэлдэхүүн  
батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 416 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгосор ТУШААХ нь:

- “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн салбар дундын оролцоог хангах үүрэг бүхий дэд хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Дэд хороонд шаардлагатай холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-т, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд салбар дундын оролцоог сайжруулж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Дэд хорооны дарга (Ж.Амарсанаа)-д, тус хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Геронтологийн үндэсний тов (Р.Оюунханд)-д тус тус үүрэг болгосугай.



200

Эрүүл мэндийн сайдын 2014 оны  
05 сарын 09 өдрийн 154 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт



“ЭРҮҮЛ НАСЖИЛТ, НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН САЛБАР  
ДУНДЫН ОРОЛЦОOG ХАНГАХ ҮҮРЭГ БҮХИЙ ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Ж.Амарсанаа, Эрүүл мэндийн дэд сайд;
- Дэд дарга: Я.Буянжаргал, Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Нарийн бичгийн дарга: Р.Оюунханд, Геронтологийн үндэсний төвийн захирал
- Гишүүд:  
Д.Амарсайхан, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;  
Г.Нандинжаргал, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;  
Ц.Доржпалам, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;  
Л.Батсайхан, Эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;  
Г.Цээсодролцоо, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Цаг уур, орчны шинжилгээний газрын дэд дарга;  
С.Золжаргал, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дэд захирал;  
О.Хуягцогт, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Зарлагын хэлтсийн дарга;  
Д.Гэрэлчулуун, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга;  
Р.Даваадорж, Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний жанжин штабын Цэргийн хангарт, үйлчилгээний газрын Эрүүл мэндийн хэлтсийн дарга;  
Д.Баттотгох, Хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн зах зээл, ажлын байр дэмжих хэлтсийн дарга;

201

Ж.Дэмжигсүрэн, Уул уурхайн яамны Төрийн захиргааны  
удирдлагын газрын ахлах мэргэжилтэн;

Л.Отгонсүрэн, Боловсрол, шинжлэх ухааны яамны  
Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын Насан туршийн  
боловсролын стандарт, хөтөлбөр хариуцсан  
мэргэжилтэн;

Н.Нямхүү, Зам, тээврийн яамны Төрийн захиргааны  
удирдлагын газрын сургалт, сурталчилгаа хариуцсан  
мэргэжилтэн;

Д.Байгалмаа, Эрүүл мэндийн яамны Бодлогын  
хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн  
хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны  
05 сарын 09 өдрийн 157 дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

“ЭРҮҮЛ НАСЖИЛТ, НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН САЛБАР  
ДУНДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮҮРЭГ БҮХИЙ ДЭД ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн салбар дундын оролцоог хангах үүрэг бүхий дэд хороо (цаашид дэд хороо гэнэ) нь хүн амын эрүүл насжих, настны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлого, үйл ажиллагааны салбар дундын уялдаа холбоо, оролцоог хангах, зохицуулахад зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус хороо байна.
- 1.2. Дэд хороо нь жилээр ажлаа төлөвлөж, Эрүүл мэндийн сайдаар батлуулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, үр дүнг тооцож ажиллана.
- 1.3. Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Гишүүдийн 50-иас дээш хувь нь ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэй гэж тооцно. Шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар гаргах ба Дэд хороооны дарга гарын үсэг зурснаар хүчинтэйд тооцогдоно.
- 1.4. Дэд хорооны хурлын тэмдэглэлийг тус хорооны нарийн бичгийн дарга хөтөлж, дарга хянаж гарын үсэг зурна.
- 1.5. Дэд хороо жилд нэгээс доошгүй удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.
- 1.6. Дэд хороо нь хэлэлцсэн асуудлаар санал, зөвлөмж, дүгнэлт гаргана.
- 1.7. Дэд хорооны гишүүн хүндэтгэх шалтгаанаар хуралд ирэхгүй тохиолдолд шалтгаанаа дарга, нарийн бичгийн даргад хурал хуралдахаас 1 хоногийн өмнө мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа бичгээр ирүүлнэ.
- 1.8. Дэд хорооны гишүүнийг өөр албан тушаалтнаар орлуулахгүй.
- 1.9. Дэд хорооноос гаргасан санал зөвлөмжийг эрүүл насжилт, настны эрүүл мэндийн хяналтад оролцогч нийгмийн салбар, байгууллагуудад албан тоотоор хүргүүлнэ.
- 1.10. Дэд хорооны хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор мэргэжлийн бусад байгууллагаас мэргэжилтнүүдийг урьж оролцуулж болно.
- 1.11. Дэд хороо нь “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг хэлэлцэн жил бүрийн 02 дугаар сарын 1-ны дотор хэлэлцэж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.

**Хоёр. Дэд хорооны үүрэг, эрх**

- 2.1. Эрүүл насжилт, настны эрүүл мэндийг дэмжих талаарх Нэгдсэн Үндэсний Байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын үзэл санаа, бодлого, үйл ажиллагааны чиглэлийг үндэслэл болгон салбар дундын хэрэгжилтийг хангах үндсэн үүрэгтэй.
- 2.2. Нийгмийн холбогдох салбар, байгууллагуудын настны эрүүл мэндийг хамгаалах дэмжих, эрүүл насжилтын талаар хийж байгаа ажилтай танилцах, энэ чиглэлийн хууль тогтоомж, тушаал, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих, түүнтэй холбогдсон асуудлаар холбогдох сайд нарын болон удирдлагын зөвлөлд санал, дүгнэлт оруулна.
- 2.3. Настны эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл насжилтын бодлого, үйл ажиллагааг хангахтай холбогдсон арга хэмжээний зардлыг эрүүл мэндийн болон бусад салбарын төсөвт тусгуулах талаар санал боловсруулж хүргүүлнэ.
- 2.4. Хүн амын эрүүл насжих, настны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлого, үйл ажиллагаа бүх салбарт хэрэгжихэд арга зүйн зөвлөмжөөр хангана.